

## СОЁЛ

Хятадын зохиолчдын залуу үеийн төлөөлөгчийн нэг бол 1942 онд төрсөн Фэн Цицай юм. Тэрээр «соёлын хувьсгал»-ын үед тухайн үеийн хятадын нийгмийн амьдралаас иш татан зохиол бичиж найз нөхөддөө ярьж сонирхуулах хэлбэрээр уран зохиолынхоо ажлыг эхэлжээ. Тэгэхдээ зохио-лынхоо үйл явдлыг үл мэдэх өөр газар оронд болгож баатруудаа харь холын хүний нэр овгоор нэрлэж байсны хүчинд «соёлын хувьсгал»-ын үеийн хатуу шийтгэлээс мултарчээ.

Дараа нь Фэн Цицай өгүүллээ жинхэнэ ёсоор бичиж нийтлүүлэх болжээ. Түүний бичсэн «Унгар унадаг дугуй», «А» нэрт тууж зэрэг бүтээл нь арван жилийн зовлон гамшигийн үеийн хэрэг явдлыг харуулна.

Тэр үеийн хэрцгий балмад хэрэг явдлыг дүрслэн, түүний хүнд хүчир хор уршгийг гэтлэн давсан утга санааг илэрхийлсэн тууж, өгүүллэгүүд сүүлийн үед хятадад их гарч байна. Түүнийг зохиогчид нь «Болшевик мэнд», «Удган эрвээхэй» тууж, «Их хотын шөнө» өгүүлэл бичсэн Ван Мэн, «Ид дунд нас» тууж бичсэн Шэнь Жун, түүнчлэн Зян Зылун, Лю Биньянь зэрэг авьяас билэгт олон зохиолчид болно.

Амьдралын хатуу сургуулийг биеэр туулсан эдгээр зохиолчид нь чухам нүдээр үзсэн зүйлээ бичиж байна. Тэдний нэгэнд орох залуу зохиолч Фэн Цицай «соёлын хувьсгал»-ын үеэр янз бүрийн хүн ямар зан гаргаж, юу хийж байсныг харуулсан 12—13 тууж бичих бодолтой байгаа талаар ярихдаа: «Тэр тухай бичих хэрэгтэй юм. Учир нь муу хорыг мартвал өөр янзаар гараад ирж мэднэ. Нөгөө талаар нийт хүмүүс, ялангуяа залуучуудыг биеээ дааж сэтгэж сурахад хэрэгтэй юм» гэжээ.

Уншигчдад товч орчуулгаар толилуулан буй Фэн Цицайгийн энэхүү өгүүллэг нь «Шанхай вэнь-сюэ» сэтгүүлийн 1982 оны тавдугаар сарын дугаарт нийтлэгджээ.

Б. Рифтин. Хэл бичгийн ухааны доктор.

## ӨНДӨР, ТАГЖГАР ХОЁРЫН ӨРТЛӨӨС

Фэн Зицай (БНХАУ)

Нэг гэрийн хоёрын гэргий нь нөхрөөсөө даруй арван долоон сантиметр өндөр. Нөхрийн нь толгой эхнэрийнхээ чихний ээмэгнээс дээш гарахгүй учир бараг хоёр толгойгоор ч нам юм уу гэлтэй. Сайн ажиглавал: эмэгтэй нь хатингар, шувтан, нүүр хэрзгөр цээжин бие хувцсаар халхлагдсан болохоор тийм гэх аргагүй, нуруу шулуун, чацархаг, ташаа нарийн. Гэтэл нөхөр нь тэс өөр, тагжгар, бүдүүн, резин бөмбөг шиг цулцгар, хүдэр гөлчгөр. Хоёр нүд нь цахилгаан гэрлийн улайх шахсан ламп л гэсэн үг. Харин гэргийнх нь бол сүүмгэр, бүдэг туяагай шилэн товч шиг санагдана. Хоёуланг нь зэрэгцүүлээд зогсоовол дүйж зохисон юм даанч үгүй гэмээр. Тэгтэл сүүдэр мэт бие биенээс салахгүй, хаана л явна хамт.

Бороотой үед гадагш гарвал гэргий нь шүхрээ барина. Тэр нь ч өөрт нь эвтэйхэн, харин юм, хүм газарт унагаачихвал нөхөр нь бөхийж авна. Тэгэх ч илүү амар харагдана.

Энэ хоёр яаж нэгнээ олоо бол? гэсэн бодол «эв нэгдэл» гэдэг өндөр байшинд суудаг хэдэн арван айл гэрийн хэрэгт дуртнуудын санаа амраадаггүй асуудлын нэг болсоор нэлээд уджээ.

Харанхуй, өргөн хонгилтой, өмнө талдаа цонхтой том том өрөөнүүд бүхий энэ байшин дээр үеийн нийтийн байр юм. Байрны урд талаар цэлийсэн ханаа, түүний үүдэнд наалдуулах шахам барьсан жижиг байшин. Энэ бяцхан байшинд оёдолчны гэр бүл амьдарна. Сайван өөрөө дуу шуугүй жожиг, харин эхнэр нь айл хэсч энэ тэрийн ярианд оролцох дуртай, бас ч хов зөөмтгий, нэн ялангуяа бусдын нууцыг байнга шиншлэнэ.

Авгай, нөхөр хоёр яаж амьдарч, бэрчүүл юунаас болж хамар мурийж, хараал тавьцааж байна, хэн нь хэдэн төгрөгний цалинтай зэргийг тэр бараглаж андахгүй.

Яагаад ч юм, 60-аад оноос иймэрхүү хүмүүс тушаал ахиж «орон сууц гудамжны идэвхтэн»-ээр бүртгэгдэн, бусдын хэрэгт оролцох дон шүгэлсэн тэдний ааш авир хууль ёсны асуудал болон хувирч, газар сайгүй хөхүүлэн сайшаагдах болов. Үүнээс үзэхэд авьяас бүр л цагаа, болоход хэрэг болдог юмсанж. Харамсалтай нь ийм хачин өндөр, нам хоёр амьтан яаж таарав? гэж сайвангийн гэргий байдаг ухаанаа заравч тааж эс чадав. Тэгэх тусам түүний хор дайр нь буцалж, дотрыг нь цухалдуулна. Тэгтэл ер нь явж явж энэ хоёрын аль нэг нь далд согогтой байх. Эс тийм бөгөөс өөрөөсөө бүхэл бүтэн нэг толгойгоор намхан хүнийг сонгож ханилах хэн байхав? гэдэг дүгнэлт хийхдээ сайвангийн гэргий зарим талаар өөрийн туршлагад тулгуурлажээ. Сүрхий ч нотолгоо олж суугаад гурван жил болсон мөртөө, хүүхэд гараагүй! Их байрныхан цөм л сайвангийн авгайн таамаглалд үнэмших болов.

Гэтэл нэг мэдсэн өндөр эмэгтэй маань бие жирэмсэн харагдах больжээ. Төдий л удалгүй «уа~уа!» гэсэн дуу гарсан нь өндөр нам хоёрт үр заяаж хорвоод шинэ хүн нэмэгдсэнийг мэдэгдсэн нярай хүүхдийн дуу осолгүй мөн байлаа. Одоо тэд гадуур явбал эмэгтэй нь хүүдээ элгэндээ тэвэрч шүхэр тагжгар нөхрийнх нь гарт шилжжээ. Тэр шүхрээ өндөр өргөж, тагалцаг бүдүүн хөлөө хурдан хурдан зөөж гэргийтэйгээ алхаа нийлүүлж ядна. Ингэж явахыг нь харахад хөгтэй нь аргагүй.

Үүнээс хойш тийм ч удсангүй сайвангийн авгай гудамжны хорооны төлөөлөгч болов. Хүн амын тоо бүртгэл болох үеэр сэргийлэгчдэд ту-

салж явсан сайвангийн авгай түүнийг хэдэн жил зовоосон нэг асуултанд хариу олж авч санаа амрах нь тэр. Юу гэвэл өндөр эмэгтэй, түүний нөхөр хоёулаа Химийн эрдэм шинжилгээний хүрээлэнд нэг дор ажилладаг аж. Гагцхүү нөхөр нь ерөнхий инженер бөгөөд сард 180 гаруй юаний цалинтай, харин гэргий нь 60 хүрэхгүй юань авдаг жирийн лаборант, удам угсааны хувьд ч гэсэн шуудан зөөгчийн гэр бүлээс гаралтай гэнэ. Тэр эмэгтэй яагаад өөрөөсөө бүтэн толгойгоор намхан, тагжгар хүнтэй нийлэв: эрх тушаал, мөнгөнд нь болж биеийн амрыг бодсон хэрэг гэдэг нь одоо нэгэнт тодорхой болов. Сайвангийн авгай энэ чухал мэдээгээ хийх юмгүй уйдсан хөршүүддээ тэр дор нь хүргэжээ.

Одоо цөм л ухаарч гэнэ. Тагжгар эр учиргүй баян, түүний мөнгөнд нь өндөр авгай шунаж суудаг байх нь. Үүнээс хойш хос хоёрын талаар ялангуяа азтай янхигар авгайн тухай хүмүүс шивэр авир ярихдаа нүд үзүүрлэж, занаж хорссон байдал илт харагдах болов.

1966 он гарлаа. Өндөр эмэгтэйн нөхөр бөөн зовлонд өртлөө. Түүний гэрийг нь нэгжиж, авдар шүүгээ бүгдийг нь гарган хаяад өөрийг нь үхрийн пинд оруулаад түгжив. Тэгээд ч зогссонгүй, хилийн чанадад суудаг баян төрөл садан дээрээ очиж тэнд улсын нууцыг худалдах зорилгоор хүрээлэнгийнхээ албаны материалыг ашиглан олон жилийн турш оройн цагаар ном бичиж, гадаадад оргох бэлтгэл хийсэн гэж ярилцах болжээ. Гэтэл, ухаанд үл багтам энэхүү чалчаа ярианд олон хүн үнэмшив. Тэр үед бүгдээрээ дээр дороо орж тонгорцоглон унаж, хүмүүс хүн төрхөө алдахад, Гитлерийн хамсаатныг илрүүлчихнэ гэж толгойтой бүр нь л горьддог байв.

Инженерийг айлган сүрдүүлж, байн байн зодож жанчих ба эхнэрээс нь огт үзэж хараагүй гар бичмэл нэхдэг болов. Гэвч хэрэг ер бүтсэнгүй. Тэгтэл их байрны хашаанд тэмцэл шүүмжлэлийн хурал хийх тухай хэн нэгний нь толгойд оржээ. Бусад аргаа нэгэнт туршиж гүйцээсэн болохоор дээрх арга л үлдсэн хэрэг бөгөөд ганц горьдлого тэр л болов.

Их байрын хөл хөдөлгөөн ер бусын нэмэгдэв. Нэг өдөр үдээс хойхно хүрээлэнгээс олон хүн ирэв. Тэд хашаан доторх моднуудын хооронд бүдүүн гэгчийн олсон аргамж татаж, харааж занасан үгтэй цаасан хуудаснууд дүүжлээд байшингийн хананд оготор инженерийн «ялт хэргүүд» гэсэн жагсаалттай арван найман хуудас наалдуулав. Хурлыг үдэш хийх болсон учир хүрээлэнгээс монтер хүрэлцэн ирж хашаан дотор утас тавьж, 500 лааны чийдэн дөрвийг зоожээ. Энэ үед сайвангийн авгай гудамжны хорооны төлөөлөгч биш, бүр журам сахиулахын даргаар томилогдож яггүй томроод байв. Түүний алба ч ширүүсч эмэгтэйчүүдийг дайчлах, хүрээлэнгийн хувьсгалчдад цай барих зэрэг ажил хөөцөлдөх бөгөөд хажууд нь бас гэрээс нь монтер гэрлийн утас залгаж авлаа. Яг л хуримын өмнөх бэлтгэл!

Оройн хоолны дараа сайвангийн авгай байрны оршин суугчдыг хашаанд цуглуулав. Хурц гэрлүүд ч аслаа. Цугларагсдын дүрс байшингийн хананд хөдлөхгүй догшин маягийн нүсэр том сүүдэр буулгана. Хүүхэд борчуул хүртэл шуугилдаж үл зүрхлэнэ. Гаднын хүн оруулахгүйн тул хаалганы хажууд ханцуй дээрээ даавуу уясан сайвангийн авгай, бусад хэдэн хүн зогсоно. Тэр үед ийм даавуу тэмдэг ямар сүртэй харагддаг гээч!

Удсан ч үгүй хүрээлэнгийнхэн бөөнөөрөө жагсаж ирэв. Тэд бас л даавуу тэмдэг боожээ. Уриа лоозон хашгирсаар, тэд өндөр эмэгтэйг нөхрийн нь хамт оруулж ирэв. Нөхрийн нь хүзүүнд банзан пайз зүүжээ. Тусгай бэлтгэсэн тавцан дээр харуул хамгаалалтын дор туугдаж гарсан тэр хоёр толгой гудайлган зогсож байв. Хажууд нь гарч ирж харагдсан сайвангийн авгай:

—Энэ новш араар зогсож байгаа хувьсгалчдад харагдахгүй байна. Би нэг арга бодлоо. Одоохон... гээд л шахцалдсан хүмүүсийн дундуур түрж гарснаа мөч хүрэхгүй хугацааны дараа савангийн том хайрцаг барьсаар гарч ирээд амыг нь уруу нь хөмөрч тавиад түүн дээрээ тагжгарыг гаргаж зогсоов. Тэр одоо гэргийтэйгээ чацуу болов. Гэвч тэрхэн тухайд тэр хоёрын өндөр намыг сонирхсон хүн огтгүй.

Хурал таггүй дүрэм горимтой эхлэв. Лоозон хашгиралдаж дуусмагц «орон тооны шүүмжлэгчид» гарч ирээд занаж зүхсэн хатуу ширүүн үгээр дайрч, дараа нь дахин лоозон хашгиралдав. Юуны өмнө өндөр эмэгтэйгээр бурууг нь хүлээлгэх гэж омоглов. Нөгөө л улигт гар бичмэлийн талаар дахин дахин байцаана. Хэл амны хурцаар эмэгтэйн зүрхэнд мэс шигтгэнэ. Чарлаа, сөөнгө, нарийн бүдүүн янз бүрийн хоолойгоор чих дөжрүүлэн, дуу хадуулж гарлаа... Гэвч өндөр эмэгтэй өчиг хүлээлгүй, зөвхөн толгой сэгсрэнэ. Тэр буруугаа шударга үгүйсгэнэ. Харамсалтай нь шударга зан сохор зоосны үнэгүй болсон цаг билээ.

Уурлаж цухалдсан залуус тавцан дээр гарч ирээд эмэгтэйн нүүр өөд гар зангидан сүрдүүлнэ. Муу юманд дуртай овжин хүмүүс мэх зохиож эмэгтэйг уриханд оруулах янз бүрийн асуулт тавьж, айлгахыг оролдсон боловч тэр өөрт тохож буй ялыг нэгд нэггүй няцаасаар байв. Хэрэв ийм янзаар цааш үргэлжилбэл шүүмжлэх хурал тарахаа мөд үзэхгүй сэн.

Сайвангийн авгай тэвчээртэй зогсож идэвхтэй сонсож байсан боловч сүүл сүүлдээ сонирхол нь буурч, бушуу тараасай гэж амандаа бувтнана. Тэр бичиг үсэггүй, том үсгийн хуудас ч уншиж чадахгүй, тийм учраас «гар бичмэл» түүний анхаарлыг өчүүхэн ч үл татна. Гэвч хүрээлэнгээс ирсэн хүмүүс өндөр эмэгтэйгээс юу ч олж долоохгүй шинжтэйг мэдсэн сайвангийн авгай гэнэт тавцан луу харайж очингуут өндөр эмэгтэйг хуруу чичин зандарч:

—За хариул, яагаад тэрүүнтэй суусан?! Хүрээлэнгийнхэн гайхах, тэвдэх нь зэрэгцлээ. Тэдний хэрэгт журам сахиулахын дарга эмэгтэйн тавьсан асуулт ямар холбогдолтойг хүмүүс ойлгосонгүй. Өндөр эмэгтэй ч бас сандрав. Хэдэн сарын турш зовлон элээсэн түүний хээ үрчлээст нүүрэнд гайхаш тасарсан байдал илт.

—Яав, хариулах зүрх хүрэхгүй байна уу? Тэгвэл би чиний өмнөөс хэлээд өгье. Чи энэ өөдгүй амьтны мөнгөнд шунаа биз дээ, тэгээгүй мөртөө чи түүнтэй суусан гэх үү? Мөнгөгүй бол энэ тайрдас хэнд хэрэгтэй юм бэ? гэж бурж гарахдаа сайвангийн авгай бах нь ханасан байртай, дуу нь чангарч байв.

Харин нөгөөдөх нь түүнийг цэх шударга хүний жигшиж шоолсон нүдээр зэрэвхийн харж дуугүй зогсоно.

—За за яахав, хүлээхгүй л байг! Энэ мангар ч зүйл дууссан, харин чи одоо яаж амь зуух гэж байна, харна даа...

Сайвангийн авгай цээжээ дэлдэж, гараа гозолзуулж, түүнийг хажуудах авгайчуул нь улам хөөргөж байв. Тэр энэ мэт санасандаа хүрч байсан нь ховор аж.

Хүрээлэнгийнхэнд чухам юу болж, яаж байгаа нь төдий л ойлгомжтой биш байв. Гэвч хэрэг явдал ийнхүү санаандгүй эргэсэн нь тэдэнд зугаатай санагдана. Авгайчуул асуултыг хорин өртөө холдуулсан боловч хурал дахин ширүүсч эхлэв. Эс тэгвэл гол зорилгоо яаж ч хангах билээ? Хэт оройтож буй учир эмэгтэйчүүд тэссэнгүй. Иймд тэднийг гэртээ харихыг зөвшөөрөв. Тэд дуугүй ч явсангүй.

—Тэр чамд хичнээн мөнгө өгдөг вэ? Хоршооноос юу авч өгдөг вэ? Ярь!

--Сарын хоёр зуун юанийг чи бага гэж чамлах уу? тэгээд бас гадаадад зугатах санаатай шүү, ээ бэрд ээ!

Хурлын амжилт хүмүүсийг харахад илхэн байв. Хүрээлэнгийнхний нүд сэргэж, онгод нь орж уриа лоозон зэрэг зэрэг хашгарцгаагаад удалгүй хурал хаасныг мэдэгдэв. Дараа нь нөгөө айлын гэрт орж шалыг нь хүртэл онгичиж ханын цаасыг хуу татаж нэгжсэн боловч юу ч олсонгүй. Тэгээд нөхрийг нь авч яваад эмэгтэйг ганцааранг нь орхив.

Маргааш өглөө нь өндөр эмэгтэйг хүүхэдтэйгээ гэрээс гарч явахад дайралдсан таних хүмүүс мэнд ч үгүй өнгөрч байв. Өчигдөр оройн хурал дээр байсан нэг нь дотроо санаа зовж гэмших мэт байдалтай боловч нүүр буруулаад л зөрөх нь тэр.

Өндөр эмэгтэйн нөхрийг аваад явснаас хойш түүний талаар зураг чимээ таг чиг. Сайвангийн урт чихтэй эхнэрийн үгээр бол тэр бас ямар нэгэн өөр хэрэгт холбогдож, шийтгүүлээд шоронд суусан гэнэ. Өндөр эмэгтэй одоо хоригдлын гэр бүл болж амьдралын хамаг ёроолд хаягджээ. Түүнд одоо өндөр байшингийн уужим өрөөнд суух хэрэгцээ ч бага болов. Гэтэл удалгүй тэр эмэгтэйг байраа сайвангийнхантай албан шаардлагаар солиулав.

Их байрны цонхоор өнөөх жижиг байшин, түүний дотор өндөр эмэгтэйн өнчин хар сүүдэр илхэн харагддаг болов. Хүүхдээ хаана хүргэж өгдөгийг нь мэдэх хүн нэг ч үгүй, харин сүүлийн үед хэд хэдэн хоногоор гэртээ байлгадаг болжээ. Амьдралын замд тохиолдсон хүчир зовлонг эх үр хоёр хоёулхнаа өдөр хоног тоолон аргацааж байв. Тэр гуч гаруйхан настай хэрнээ хамаагүй оворжуу харагдана.

Нэгэн жил өнгөрлөө. Намхан нөхөр ч ирсэнгүй. Өндөр эмэгтэй ч өнөө хэвээрээ л нам жим, ганцаардмал орчинд амь зуусаар байж. Дөнгөж ажлаас ирэнгүүт зуухаа галлана, сийрхий том шар сагсаа бариад ногоонд явна.

Дахин нэг жил өнгөрлөө. Гэтэл нэг өдөр нөхөр нь ирж харагдав. Намар оройтсон цаг. Нимгэн сармай хувцастай, үсээ авахуулжээ. Танигдахгүй болтол өөрчлөгдөж, цус бутарсан хүрэн царай нь цонхийж, нугалуур шиг бөөрөнхийгээс нь юу ч үлдсэнгүй. Өндөр эмэгтэй үүдний хажууд өлмий дээрээ сууж гишүү хугална. Нөхрийн мэндлэх дуугаар тэр босон харайж тэвдсэн байдалтай гөлрөн харна. Дараа нь гэртээ гүйж ороод удтал харагдсангүй. Харин нөхөр нь гарч ирээд сүх авч явган суугаад ажилд орлоо.

Тэр өдрөөс хойш нөгөө хоёр хуучин зангаараа бие биеэс сүүдэр мэт үл харагцан, хамт ажилдаа явж хамт буцаж ирнэ. Өндөр байрны айлууд онцгой гойд юу ч ажиглахаа байж, тэр хоёрын талаар сонирхол нь ч аажимдаа буурчээ. Тэдэнтэй зууралдах хэрэг ч байсангүй.

Гэтэл нэг өглөө ямар нэгэн явдал гарсан бололтой. Нөхөр нь айж сандарсан байдалтай гараад гүйж харагдана. Удсан ч үгүй «түргэн тусламж» ирээд эмэгтэйг аваад явлаа. Түүнээс хойш жижигхэн байшинд оройн цагаар гэрэл асахаа байгаад нэлээд удав. Хорь орчим хоногийн дараа нөхөр нь үл таних нэг хүнтэй хамт өндөр эмэгтэйг дамуурга дээр авч ирэв.

Эмэгтэй гэрээс гарахаа больжээ. Түүний намхан нөхөр урьд адил өглөө албандаа явж үдэш эргэж ирээд гал тогоо барина. Зуухаа галлачихаад сагсаа барьж ногоонд гарна. Сагс нь өндөр эмэгтэйн ноднин, уржнан бариад өдөр бүр дэлгүүрт явдаг нөгөө л том сагс агаад харин түүний гарт дэндүү томдож, ёроол нь газар шүргэх шахна.

Жилийн дараа, дахин урин дулаан болсон цаг, өндөр эмэгтэй пингээсээ анх удаа цухуйлаа. Удаан нар үзээгүй угийн царай муутай өндөр эмэгтэйн өнгө зүс нь зэвхий цагаан болж гүйцжээ. Хөл нь дайвна. Ба-

руун гартаа хулсан таяг тулах бөгөөд зүүн гар нь сойлготой байна. Зүүн хол мэдээгүй учир дөнгөн данган зөөж гишгэнэ. Харваас цус харвасан нь илэрхий.

Түүнийг одоо намхан нөхөр нь өглөө, орой болгон түшиж хашаан дотуур хоёр тойрно. Тэр хоёр мөн ч төвөгтэй, мөн ч алгуур хөдлөнө! Гэргийнхээ тохойг нөхөр нь хоёр гардаа түшихэд нуруу намхан болохоор гараа чилтэл сунгаж мөр нь өргөөстэй. Түүний ийнхүү мэрийн явахыг харвал инээдээ барихад хялбаргүй.

Өндөр эмэгтэй мэдээгүй болсон зүүн хөлөө өргөж чадахгүй тул боосон боодлоос нь хүчээр чангааж алхам ахиулна. Үүнийг харсан хүнд элэг шимширмээр... Их байрны хүмүүс энэ хоёрыг аргагүйн эрхэнд өрөвдөх сэтгэл төрнө.

Хэсэг хугацаа өнгөрөөгөөд өндөр эмэгтэй амьдралтай салахын ёсыг гүйцэтгэжээ. Харин бяцхан нөхрийг нь цагаатгав. Тэр хураагдсан юмаа эргүүлэн авч, түүнд урьд нь цалингаас нь барьж авч байсан бүх зөрүүг нөхөж олгожээ. Эднийх юу болох гээд байна? гэж зарим айл хөршийнхөн нь харж ширтэх ч болов.

—Түрүүнд юу хэрэгтэйг би мэдэж байна. Гайгүй та нар хараарай! гэж сайвангийн авгай айлддаг байна.

Сайвангийн авгайн хувьд манддаг үе нь нэгэнтээ өнгөрчээ. Тэр эрх тушаал бууснаас хойш дуу нь намдаж, эелдэг болжээ. Нэг өдөр сайвангийн авгай зээ бүсгүй болох залуухан эмэгтэйнхээ зургийг өвөртөлж аваад намхан нөхрийнд яваад оржээ. Тэр гэрийн доторхийг эргэн тойрон хараад «баян»-ыг гэрлүүлэх талаар ятгаж эхлэв. Инээхэд нь түүний нүүрний арьс тэлнэ. Тэр байдгаа дэлгэж хэлээд харсан чинь намхан эр дув дуугүй бөгөөд өөр тийш харжээ. Түүний царай нь барайгаад, сүртэй. Сайвангийн авгай түүний ширтсэн зүг рүү нь харвал хос хоёр хуримынхаа дараа татуулсан гэрэл зураг хананд өлгөөстэй. Сайвангийн авгай зээ бүсгүйнхээ зургийг гаргаж ч зүрхэлсэнгүй, явахын түүс боллоо.

Нэлээд жил өнгөрчээ. Нам эрэгтэй одоо хэр нь ганц бие. Ням гариг бүр хүүгээ гэртээ авч ирнэ. Өндөр байрны хөршүүд ч тэр яагаад ганц бие амьдрахаар шийдсэнийг ойлгодог болсон бололтой.

Бороо ороход намхан нөхөр маань шүхрээ өөрөөсөө бага зэрэг хажуу тийш нь өндөр өргөж явдаг нь сурсан заншилынх. Ажваас шүхэрийнхээ доор хэн нэгэн хүнд зай үлдээсэн мэт. Тэр зай хоосон, яагаад гэвэл энэ хорвоод ямар ч гарз үл нөхөгдөнө.

«Литературная газета», 1983 оны хоёрдугаар сарын 23-ны дугаараас **Э. Пунцаг** орчуулав.